**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

…АМАРЖАРГАЛ

**НИЙЛҮҮЛЭГЧ**

"АЗИФАРМА" ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЯРЖАРГАЛ

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 09

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас …Фарма ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож …20 оны 02 дугаар сарын 10-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) …зүүлав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь эмийн худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 77,000,000 (далан долоон сая) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Барааны нэр, төрөл | Багц ийн дугаа | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Осельтамивир 75мг | №1 | Yuhan corporation / БНСУ | хайрцаг | 2000 | 29000 | 58,000,000 |
| Осельтамивир 45мг | №2 | Yuhan corporation / БНСУ | хайрцаг | 1000 | 19000 | 19,000,000 |
| **Нийт дүн** | | | | | | **77,000,000** |

Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 77,000,000 (далан долоон сая) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Нийлүүлэгч нь 2 нэр төрлийн барааг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Осельтамивир 75мг | №1 | | 58,000,000 |
| 2 | Осельтамивир 45мг | №2 | | 19,000,000 |
| | **Нийт дүн** | | | **77,000,000** |

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг.

| | |
|---|---|
| ГЕН 23 | ГЕН-ийн 23-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 24)** | |
| ГЕН 24 | ГЕН-ийн 24-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)** | |
| ГЕН 25 | ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)** | |
| ГЕН 26 | ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)** | |
| ГЕН 27.1 | Монгол хэл |
| **28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)** | |
| ГЕН 28.1 | Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө |
| **29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)** | |
| ГЕН 29.1 | Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2 |
| **30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)** | |
| ГЕН 30 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

..........................................Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

..........................................Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

..........................................Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

..........................................Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бодогч

..........................................Х.Ариунтуяа

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн

..........................................Б.Мөнхцэцэг

*14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр Утас:263695*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"АзиФарма" ХХК Тендерийн албаны дарга

.................................. З.Цэрэнхүү

*Хаяг: Гранд Плаза цогцолбор №1105, БГД 2-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс*
*Утас: 8801 4487*

*Харилцах банк*
*ХААН банк*
*5021019647 /төгрөг/*